

## 2024 ОНД 1826 КМ ТӨМӨР ЗАМЫН БАРИЛГЫН АЖЛЫГ ЭХЛҮҮЛЖ, ШИНЭЭР 21 ЗҮТГҮҮР АВЧ, ХӨДЛӨХ БҮРЭЛДЭХҮҮНЭЭ НЭМЭГДҮҮЛНЭ

📍 2024 онд 1826 км төмөр зам барих барилгын ажлыг эхлүүлнэ. Тодруулбал, баруун босоо чиглэлийн Арцсуурь-Нарийнсухайт-Шивээхүрэн чиглэлийн 1255 км төмөр зам, зүүн босоо чиглэлийн Чойбалсан-Хөөт-Бичигт чиглэлийн 426.6 км төмөр зам, Сайншанд-Баруун-Урт-Хөөт чиглэлийн 430 км төмөр замуудын барилгын ажлыг эхлүүлэхээр төлөвлөөд байна.

📍 Шивээхүрэн-Сэхэ чиглэлийн 19.6 км төмөр зам, Зүүнбаян-Ханги чиглэлийн 226.9 км төмөр замыг байнгын ашиглалтад оруулахаар төлөвлөсөн.

📍 Мөн Улаанбаатар төмөр замын төв коридорын шинэчлэлийн ажил, Сайншанд-Зүүнбаян, Эрээнцав-Чойбалсан чиглэлийн их засварын ажлыг үе шаттайгаар үргэлжлүүлэн хийнэ